

УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ЗАХИРГААНЫ
ХЭРГИЙН ТАНХИМД

Хяналтын журмаар гомдол гаргах нь

“Хюман стэйшн интернэшл” ХХК-ийн нэхэмжлэлтэй, Гаалийн улсын байцаагч Ш.Батболдод холбогдох “0012519 тоот шийтгэлийн хуудсыг хүчингүй болгуулах” шаардлага бүхий захиргааны хэргийг Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүх 2024 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 103 дугаар шийдвэрээр нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд хангаж шийдвэрлэснийг, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх хариуцлагын гарсан гомдлыг үндэслэн 2024 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр 0259 тоот маргаалаар Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 103 дугаар шийдвэрийг бүхэлд нь хүчингүй болгон нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгон шийдвэрлэсэн. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 0259 тоот тус маргалдлыг эс зөвшөөрч нэхэмжлэлийн төлөөлөгч Ч.Ганболд би Захиргааны хэргэ шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 123.2.3, 123.2.4-т заасан үндэслэлээр хяналтын журмаар гомдол гаргаж байна.

1. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 123.2.3-т заасан “хуульд Улсын дээд шүүхийн тогтоол, тайлбараас өөрөө хэрэглэсэн” гэх үндэслэлийн тухайд:

Зөрчлийн тухай хуулийн 1.4 дүгээр зүйлийн 4 дэх заалтад “Зөрчлэлд тооцогүй болсон, оногдуулах шийтгэл, албадлагын арга хэмжээг хөнгөрүүлсэн, зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдийн эрх зүйн байдлыг дээрдүүлсэн хуулийг буцаан хэрэглэнэ” гэж заасан. Миний бие Ч.Ганболд нь давж заалдах шатны шүүх хуралдаанд оролцоходоо 0012519 тоот шийтгэлийн хуудаст тусгагдсан “тусгай зөвшөөрлийн хуулийн этгээд биологийн идэвхт бүтээгдэхүүнийг импортлоход тусгай хэрэгжиж эхэлснээр биологийн идэвхт бүтээгдэхүүнийг импортлоход тусгай зөвшөөрөл шаардахгүй болсон тул Зөрчлийн тухай хуулийг буцаан хэрэглэх ёстой гэж тайлбарласан боловч Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхээс энэ талаар ямар нэгэн дүгнэлт гаргалгүйгээр нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон.

Эм, эмнэлгийн хэргэлийн тухай хууль нь 2010 оны 06 дугаар сарын 10-ны өдөр батлагдсан байх бөгөөд тус хуулийн 7.1-т “Хүний эм, эмнэлгийн хэрэгсэл болон мансууруулах эмгэгэд нөлөөлөх эм, мэдрэлийн утсаар бодис, биологийн үрбэлт бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, импортлох, худалдах тусгай

Зөвшөөрөл эмийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага олгоно" гэж заасан байсныг 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр "Хүний эм, эмнэлгийн хэрэгсэл болон мансуургуулах, сэтгэцэд нөлөөлөх эм, тэвгээрийн үгтвэр бодис үйлдвэрлэх, импортлох, экспортлох, худалдах, ханган нийлүүлэх тусгай зөвшөөрлийг эмийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага олгоно" гэж өөрчлөн найруулсан. Тодруулбал, Эм, эмнэлгийн хэрэгсэл тухай хууль анх батлагдан гарч байх үед биологийн идэвхт бүтээгдэхүүнийг импортлоход иргэн, хуулийн этгээд тусгай зөвшөөрөл авсан байх шаардлагатай байсан бол 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрөөс эхлэн биологийн идэвхт бүтээгдэхүүнийг импортлоход тусгай зөвшөөрөл шаардахаа больсон. Энэ талаар Зөвшөөрлийн тухай хуульд мөн зохицуулсан. Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлд тусгай зөвшөөрлийн жагсаалтыг баталсан бөгөөд 8.1 дүгээр зүйлийн 13 дахь заалтад эрүүл мэндийн чиглэлээр тусгай зөвшөөрөл шаардагдах үйл ажиллагааны төрлүүдийг тусгасан. Тус жагсаалтын 13.16-д "Биологийн идэвхт бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, импортлох, экспортлох, ханган нийлүүлэх" үйл ажиллагаа нь тусгай зөвшөөрөл авахаар зохицуулагдсан байсныг, 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон. Өөрөөр хэлбэл, биологийн идэвхт бүтээгдэхүүнийг импортлоор Монгол Улсад оруулж ирэхэд хуулийн этгээд нь тусгай зөвшөөрөл авсан байх шаардлага нь 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрөөс эхлэн дусгавар болсон тул Зөвшөөрлийн тухай хуулийн 1.3 дугаар зүйлийн 1-т заасны дагуу тус үйл ажиллагааг хууль тогтоомжид нийцүүлэн чөлөөтэй эрхэлж болохоор байна.

Галийн Улсын Байцарч Ш.Батболд нь дээрх хуулийн зохицуулалтын өөрчлөлт орохоос 2 сар гаруй хугацааны өмнө буюу 2022 оны 10 дугаар сарын 17-ны өдөр 0012519 тоот шийтэлийн хуудсыг үйлдэж "Хюман стэйшн интернэшл" ХХК-д шийтгэл оногдуулсан. Шийтгэл оногдуулах үед биологийн идэвхт бүтээгдэхүүнийг импортлох хуулийн этгээд тусгай зөвшөөрөл авсан байх хуулийн шаардлага тавигдаж байсан тул тус шаардлагыг зөрчсөн байх нь Зөрчлийн тухай хуульд заасанд "зөрчил"-д тооцогдож байсан байна. Гэсэн хэдий ч 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрөөс тус зохицуулалт өөрчлөгдөж дээр дурдсанчлан тусгай зөвшөөрөл шаардахгүй болсон тул энэ төрлийн үйл ажиллагаа нь "зөрчил"-д тооцогдохоо больсон. Энэ нь Зөрчлийн тухай хуулийн 1.4 дүгээр зүйлийн 4-д заасан **"Зөрчлийн тооцохгүй болсон"**, оногдуулах шийтгэл, албадлагын арга хэмжээг хөнгөрүүлсэн, зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдийн эрх зүйн байдлыг дээрдүүлсэн хуулийг буцаан хэрэглэнэ" гэх үндэслэлд хамаарч байна.

Монгол Улсын Дээд Шүүхийн 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 11 дүгээр тогтоолоор баталсан "Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 2 хэсгийг хэрэглэх талаар албан ёсны тайлбар"-т материаллаг болон процессын хэм хэмжээнд хуулийг хэрхэн буцаан хэрэглэх талаар тусгагдсан. Тус тайлбарт "эрүүлийн эрх зүйн материал хэм хэмжээ нь хэргийн үйл баримтаас хожим

үйлчилж эхэлсэн ч шүүгдэгчийн хувьд *in mitis* (ашигтайгаар) байдаггүй бол аливаа процессын шинжтэй хэм хэмжээ нь мөн чанараасаа факто (Өмнөх үйл баримтад хуульч хэрэглээг буюу хуульч буюу *facto*) болон хэрэглээг боломжтой. Буцаан хэрэглэх боломжтой хуулийг ерөнхийд нь *ex post* шалтгаалан энэ ангилалд багтаагүй.

Зөрчлийн тухай хуульч нь зөрчлийн шинж, онолдуулах шийтгэл, чөлөөлөх үндэслэл зэргийг зохицуулсан тул материаллаг хэм хэмжээнд хамаарах нь маргаангүй юм.

Иймд, материаллаг хэм хэмжээ буюу Зөрчлийн тухай хуулийг буцаан хэрэглэх боломжтой нөхцөл үүссэн байхад шүүхээс хуульч буцаан хэрэглэх тус зохицуулалтыг хэрэглээгүй нь Монгол Улсын Дээд Шүүхийн 2022 оны 03 дугаар 09-ний өдрийн 11 дүгээр тогтоолоор баталсан тайлбарыг хэрэглээгүй буюу өөрөөр хэрэглэсэн тохиолдолд хамаарч байна.

2. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 123.2.4 "эрх зүйн шинэ ойлголт, эсхүл хуульч хэрэглээг тогтооход зарчмын хувьд нийтлэг ач холбогдолтой" гэх үндэслэлийн тухайд:

Гомдлын нэг дэх хэсэгт дурдсанчлан Улсын Их Хурлаас баталсан 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуулиар "Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын тухай" хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийг өөрчлөн найруулахдаа биологийн идэвхт бүтээгдэхүүний тусгай зөвшөөрөлтэйгөөр импортолох тухай өмнөх хуулийн зохицуулалтыг хассан ба "Зөвшөөрлийн тухай" хуулийн 8.1 дүгээр зүйлийн 13.16 "Биологийн идэвхт бүтээгдэхүүний тусгай зөвшөөрөлтэйгөөр импортолоно" гэх агуулга бүхий зохицуулалтыг хүчингүй болгосон зарийг харгалзан үзвэл 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрөөс эхлэн Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульч болон зөвшөөрлийн тухай хуульч зааснаар биологийн идэвхт бүтээгдэхүүнийг импортоор оруулж ирэхэд тусгай зөвшөөрөл авсан байх хуулийн шаардлага тавигдахаа больж, тус үйл ажиллагааг чөлөөтэй эрхэлж болоход болсон байна. Гэтэл Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 15.9 дүгээр зүйлийн 15.9.3-т тусгай зөвшөөрлийн тухай хуулийн зохицуулалтыг хэрэглэхэд, иргэн эм, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхт бүтээгдэхүүнийг импортолохыг хориглоно гэж заасан нь УИХ-ийн 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан, хүчингүй болгосон дээрх зохицуулалтуудтай зөрчилдөж байна. Тиймээс биологийн идэвхт бүтээгдэхүүнийг импортолоход тусгай зөвшөөрөл авах шаардлагатай юу, эсхүл тус үйл ажиллагааг чөлөөтэй эрхэлж болох уу гэдгийг шийдвэрлэх нь цаашд үүнтэй төстэй маргаан шийдвэрлэхэд хуульч хэрэглээг тогтооход зарчмын хувьд нийтлэг ач холбогдолтой байна.

Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын тухай хуулийн 15.9.3-т заасны дагуу тусгай зөвшөөрөлийг хуулийн этгээд биологийн идэвхт бүтээгдэхүүнийг импортолохыг хориглож буй нь тус үйл ажиллагааг эрхлэх этгээдэд тусгай зөвшөөрөл авсан байх шаардлагыг тавьж байна гэж үзвэл тус тусгай

зөвшөөрлийг ямар байгууллагаас хэрхэн авах талаарх зохицуулалт хуульд байх ёстой. Гэтэл энэ талаар ямар ч зохицуулалт байхгүй байна. Мөн Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 13.16-д "Биологийн идэвхт бүтээгдэхүүнийг импортлох тусгай зөвшөөрлийг эмийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага олгоно" гэж заасныг хүчингүй болгосноор тус үйл ажиллагааг иргэн, хуулийн этгээд чөлөөтэй эрхлэн явуулах талаар хууль тогтоогч хүсэл зорилго илэрхийлсэн байна.

Түүнчлэн, бодит амьдрал дээр 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрөөс хойш иргэн, аж ахуй нэгжүүд нь тусгай зөвшөөрөл авалгүйгээр Биологийн идэвхт бүтээгдэхүүнийг импортлох үйл ажиллагааг чөлөөтэй эрхэлж байгаа ба үл ажиллагааг зөрчлөд тооцохоо больсон зэрэг нь Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын тухай хуулийн 15.9.3-д "Биологийн идэвхт бүтээгдэхүүн"-ийг хамруулсан нь хуулийн "хийдэл" болохыг харуулж байна.

Иймд, "Хюман стэйшн интернэшнл" ХХК нь тусгай зөвшөөрөлгүйгээр Биологийн идэвхт бүтээгдэхүүнийг импортлосон үйлдэл нь одоо мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийн дагуу "зөрчил"-д тооцогдох оо больсон ба Зөрчлийн тухай хуулийн 1.4 дүгээр зүйлийн 4-д зааснаар хууль буцаан хэрэглэх үндэслэлтэй байсан байна. Гэтэл Захиргааны хэрэг заалдах шатны шүүх хэргийг бүхэлд нь хянах үүрэгтэй хэрнээ энэ талаар тайлбарласаар байхад ямар ч дүгнэлт хийгээгүйгээс маргалдал хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх шаардлагыг хангахгүй нөхцөлд хүргэсэн байна. Тиймээс Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2024 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр 0259 тоот маргалдал хүчингүй болгож, Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж, нэхэмжлэлийг бүхэлд нь хангаж өгнө үү.

-Улсын тэмдэглэлийн хураамж төлсөн баримт хавсаргав.

НЭХЭМЖЛЭЛИЙН ИТГЭМЖЛЭГДСЭН

ТӨЛӨӨЛӨГЧ

Ч.ГАНБОЛД